

**“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН  
БАЙГУУЛЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Захирлын баталсан “Өсвөр үе хүнс” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах 2023 оны ажлын төлөвлөгөө”-ний дагуу хяналт шалгалтыг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдөр, 08 дугаар сарын 15-ны өдрөөс 22, 12 дугаар сарын 19-ны өдрөөс 24-ний өдрүүдийн хооронд тус тус зохион байгуулж өдрүүдийн хооронд тус тус зохион байгуулж, Дотоод хяналт шалгалтын комисс буюу менежер Б.Зоригоо, ерөнхий нягтлан бодогч Ш.Отгонжаргал, хүний нөөц, ХАБ хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

№	Хяналт шалгалтын чиглэл	Хэрэгжилт, хийгдэж буй ажил	Хангалттай эсэх	Илэрсэн асуудал, зөрчил дутагдал	Зөвлөмж, санал, дүгнэлт
1	Харилцагч цэцэрлэг, сургуульд нийлүүлэх барааны чанар, аюулгүй байдал	1.1.“Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу 2022-2023 оны хичээлийн жилд Баянзүрх, Хан-Уул дүүргийн 83 цэцэрлэг, 15 сургуулийн нийт 164 гаруй хичээлийн байранд 23 нэрийн 110 орчим төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг захиалгын дагуу нийлүүлж ажилласан. 1.2.Хүнсний тухай болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гэрээт байгууллага болох “Само институт” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторитой хамтран ажилладаг.Нийт 110 нэрийн нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг гэрээт нийлүүлэгч байгууллагууд итгэмжлэгдсэн лабораторид хими болон нян			Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн чанар стандартын шаардлага хангасан эсэх болон лабораторийн шинжилгээний хариуг бүтээгдэхүүн тус бүрээр сар бүрийн 1-ний өдөр харилцагч цэцэрлэг, сургуулиудад хүргүүлдэг.  Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох үйл ажиллагааг "Урагш нэг шат" бүртгэлийг хүлээж авч байгаа бүтээгдэхүүн тус бүрээр цахимаар үйлдэж архивлан хадгалдаг.

		<p>судлалын шинжилгээнд хамруулж тус байгууллагад гэрээний дагуу нийлүүлдэг.</p> <p>Чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хүлээн авч, харилцагч цэцэрлэг сургуульд нийлүүлж, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.</p> <p>1.3. Үйлдвэр хөдөө аж ахуй сайдын 2013 оны А/98 дугаар тушаалын дагуу “Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ын дагуу аж ахуй нэгж байгууллагаас бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа бүтээгдэхүүн тус бүрээр дотооддоо түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнээр нь ангилан кодолж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох үйл ажиллагааг "Урагш нэг шат", "Хойш нэг шат" бүртгэл хөтлөлтөөр үйлдэн гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.</p> <p>1.4. “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 12.4. “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” MNS 6648:2016 стандартад заасан шаардлагыг хангахаар байгууллагын эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан хүнсний бүтээгдэхүүнийг сав баглаа боодол, шошгололтолын байдалд хяналт тавьж, нийлүүлэгч гэрээт байгууллагаас ирж байгаа бүтээгдэхүүн тус бүрээр шалгаж агуулахад хүлээн авч байна.</p>	Тийм		<p>Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох "Хойш нэг шат" бүртгэлийг 110 нэр, төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдэд харилцагч цэцэрлэг, сургуулиудад бараа тус бүрээр өдөр тутам хүргүүлдэг. Давхардсан тоогоор 2023 оны жилийн эцсийн байдлаар 2500 гаруй ул мөрийг мөрдөн тогтоох "Хойш нэг шат" бүртгэлийг хүргүүлж, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан байна.</p>
--	--	---	------	--	---

1.1	Агуулахын стандартын хэрэгжилт	<p>Тус байгууллага нь хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг өөрийн 8 агуулахад:</p> <p>1.1.1. Агуулахад стандарт норматив баримт бичгийн шаардлагыг хангасан, гарал үүслийн гэрчилгээтэй, хүний эрүүл мэндэд аюулгүй талаар эрх бүхий байгууллагын дүгнэлттэй бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч байна.</p> <p>1.1.2. Агуулахад бараа бүтээгдэхүүнийг стандарт, техникийн баримт бичигт заасан нөхцөл горимын дагуу хадгалдаг.</p> <p>1.1.3. Хүнсний бараа, бүтээгдэхүүн, түүхий эд жимс жимсгэнэ, хүнсний ногоог 0-10<sup>0</sup>С бүхий хөргөлттэй, 60%-иас дээшгүй харьцангуй чийглэгтэй нөхцөлд хадгалдаг.</p> <p>1.1.4. Түүхий махыг агуулахад хасах 18<sup>0</sup>С-аас доошгүй хэмд хадгалдаг</p> <p>1.1.5. Агуулахад температур, харьцангуй чийг хэмжигч 8 багажийг хаалга болон ууршуулагчаас хол, харагдахуйц газар байрлуулж хэмжилтийг өдөр бүр хийж, тэмдэглэл хөтөлдөг.</p> <p>1.1.6. Бараа бүтээгдэхүүнийг бүлэглэн ангилж, технологийн дагуу байршуулах, хурааж хадгалах зарчмыг баримталж байна.</p> <p>1.1.7. Тавиурын нүүрэн талд барааны бүлэг, нэр төрөл, байршил, нөөц тоо хэмжээ зэрэг үзүүлэлтийг тодорхойлсон хаяг тэмдэглэгээг хийдэг.</p> <p>1.1.8. Бүтээгдэхүүнийг шалнаас 20 см, хананаас 50см, гэрэлтүүлэг болон халаалтаас 1м-ээс багагүй зайд хадгалдаг.</p> <p>1.1.9. Хүнсний бүтээгдэхүүний агуулахад хүнсний биш бараа, ахуйн химийн бараа, сав</p>	Тийм	Тус байгууллага нь хүнсний зориулалтын агуулах байхгүй боловч өөрийн ажлын байрны онцлог тохируулан бололцооны хэмжээнд засаж, тохижуулан ажилладаг.	<p>Хүнсний зориулалтын агуулах, байртай болох асуудлаар холбогдох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж ажиллах</p> <p>Хүнсний бүтээгдэхүүний агуулах, түгээлтийн тээврийн хэрэгсэл бүрд градус хэмжих 12 багажийг байрлуулсан, өдөр тутам 3 удаагийн давтамжтай хэмжилтийг эрүүл ахуйн асуудал хариуцсан хийж, бүртгэл хөтөлж хэвшсэн байна.</p>
-----	--------------------------------	---	------	--	--

		баглаа боодлын материалыг хамт хадгалдаггүй.			
2	Ажлын байрны эрүүл ахуй, халдвар хамгаалал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт /2 цаг тутамд цэвэрлэгээ хийсэн байдал/	2.1.Ажилтнууд өөрийн ажлын ширээ сандал, компьютер, шүүгээ зэрэг албан тасалгаанд буй хүний гар хүрэх гадаргууг 2 цаг тутамд жавелионы 0,015% уусмалаар /10 л усанд 1 ш жавелион эсвэл 1литр усанд 1 таг близна/ тус тус шүршиж арчдаг. 2.2.Өдөрт 2 удаа цэвэрлэгээ ариутгалыг тогтмол хийж шал, ариун цэврийн өрөө, угаалтуур зэргийг жавелионы 0,06% уусмалаар /10 л усанд 4 ш жавелион/ чийгтэй цэвэрлэгээг хийж байна.	Тийм	Байхгүй	Тоног төхөөрөмж эд хогшлын ариутгалын бүртгэлийг тогтмол хөтөлж байна, ариутгалын байдалд эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан байнгын хяналт тавьж ажиллаж, бүртгэлийг тогтмол хийж байна.
3	Хүнсний бүтээгдэхүүний татан авалт, түгээлт, тээврийн хэрэгслийн стандарт, ариун цэврийн байдал	3.1.Агуулахаас түгээлтийн автомашинд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зөөвөрлөхдөө дараах байдлаар шалгаж хүлээж авдаг. Үүнд: 3.1.1.Барааг хүлээн авахдаа гадна уут, сав, баглаа боодол нь эвдэрч, гэмтээгүй, мэдрэхүйн үзүүлэлтээр өнгө, үнэр, гадаад байдал нь муудаж өөрчлөгдөөгүй, хаяг, шошгын мэдээлэл нь бүрэн гүйцэт, үйлдвэрлэсэн он, сар, өдөр нь үнэн зөв тавигдсан эсэх, хэрэглэх болон хадгалалтын хүчинтэй хугацааг шалгаж ачдаг. 3.1.2.Тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дагалдах лабораторийн шинжилгээний сорилтын дүн, улсын байцаагчийн дүгнэлт, гарал үүслийн гэрчилгээ зэргийг ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн хуудсын хамт заавал хүлээн авч, ул мөрийг	Үгүй	Ачигч нар хүнсний бүтээгдэхүүн түүхий эдийг зөөвөрлөхдөө сав баглаа боодлыг гэмтээдэг, хайрцаг савыг зөөх явцад эвдэлдэг зэрэг нийтлэг зөрчлүүд гарч байна.	Тус үйлдвэрийн газар нь хүнс түгээлтийн 5 автомашинтай. Өмнө жил бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт өсөж, олон салбар цэцэрлэгүүд шинээр байгуулагдсан тул өнгөрсөн оны 11-р сард 1 түгээлтийн автомашиныг тендерээр худалдан авсан. Тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй жолооч тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг явуулж байна. Түгээлтийн нярав,жолооч, ачигч нар жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, эрүүл ахуйн шаардлага хангасан улирлын ажлын хувцсаар бүрэн хангагдсан.

		<p>мөрдөн тогтоох “урагш нэг шат” бүртгэлийг хөтөлдөг.</p> <p>3.1.3. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүнсний сүлжээний дараагийн үе шатанд буюу харилцагч цэцэрлэг, сургуулиудад дагалдах лабораторийн шинжилгээний сорилтын дүн, улсын байцаагчийн дүгнэлт, гарал үүслийн гэрчилгээ зэргийг ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн хуудсын хамт хүлээлгэн өгч, ул мөрийг мөрдөн тогтоох “хойш нэг шат” бүртгэлийг байнга хөтөлдөг.</p> <p>3.1.4. Барааг шалгаж хүлээн авах явцад сав, баглаа боодол нь урагдаж, гэмтсэн, муудсан, хаяг, шошгын зөрчилтэй, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн хуудасгүй бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нэн дариу буцаах арга хэмжээ авч, бүртгэл хөтөлдөг.</p> <p>3.1.5. Түргэн гэмтэх, эмзэг хүнсний бүтээгдэхүүнийг хөргөх, хөлдөөх нэмэлт төхөөрөмжөөр тоноглосон, дулаан тусгаарлагчтай бүхээгтэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн, тээвэрлэлтийн үеийн хэмийг бүртгэдэг</p> <p>3.1.6. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг эхэлж орсон нь эхэлж гарах зарчмын дагуу, хамгийн доод хэсэгт түүхий, дунд хэсэгт, хагас боловсруулсан, хамгийн дээд хэсэг бэлэн бүтээгдэхүүнийг байрлуулах байдлаар хэт чигжиж ачааллыг хэтрүүлэхгүйгээр өрж тээвэрлэдэг.</p> <p>3.1.7. Тээвэрлэлт, ачиж буулгах явцад ачааны бүрэн бүтэн байдал, чанарыг алдагдуулахгүйн тулд стандартын баглаа боодол, сав хайрцаг,</p>		<p>Мөн автомашины кабинд хувийн хамгаалах хэрэгсэл маск, бээлий, спиртэн суурьтай гар ариутгалын бодисыг хангалттай хэмжээний нөөцтэйгээр тавьж хэвшсэн.</p>
--	--	--	--	--

		шошго, хаяг битүүмжлэл зэргийг урьдчилан хангуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.			
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, журмын хэрэгжилт	<p>4.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.</p> <p>4.1.1.Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Анхан болон урьдчилсан зааварчилгаа, давтан зааварчилгааг өгч ажиллаж байна. Давтан зааварчилгааг өдөр бүр ажилд гарахын өмнө холбогдох ажилтанд өгч бүртгэл хөтөлж, гарын үсэг зуруулж ажилд гаргаж байна. 2023 онд нийт 11 ажилтан шинээр ажилд орсон тул дээрх ажилчдад 2021 оны 11-р сарын 01-ний өдөр батлагдсан “Ачигчийн гараар ачаа өргөх, зөөх, шилжүүлэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”, “Жолоочийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г тус тус танилцуулж Анхан шатны зааварчилгааны дэвтэрт гарын үсэг зуруулж баталгаажууллаа</p> <p>Өдөр тутмын зааварчилгааг галын аюулгүй байдал, нярав, жолооч, ачигч, үйлчлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгаа гэсэн төрлөөр тус тус шинэчлэн боловсруулсан.</p> <p>Анхан шатны болон урьдчилсан зааварчилгаа болох “Жолоочийн</p>	Тийм	Байхгүй	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна.

	<p>хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, “Ачигчийн гараар ачаа өргөх, зөөх, шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г шинэчлэн боловсруулж 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр батлуулсан.</p> <p>4.1.2. Ажлын тусгай хувцсыг 2023 жилийн эцсийн байдлаар хуваарийн дагуу нийт жолооч, ачигч, үйлчлэгч нарт давхардсан тоогоор 128 ширхэг 7,649,400 төгрөгний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан махны, ногооны, өдөр тутмын гэсэн 3 ээлжийн ажлын хувцсыг захиалгаар хийлгүүлж, ажилтны хэвийн ажиллах нөхцлийг хангаж ажилласан.</p> <p>Хувийн хамгаалах хэрэгсэл болох амны хаалт, бээлийгээр өдөр тутам хангаж хэвшсэн.</p> <p>Нурууны хамгаалах бүс PW-80 загварын 11 хамгаалах бүсийг шинээр худалдан авч шинээр ажилд орсон ажилтан болон хамгаалалтын бүс нь муудсан ажилтнуудад олгосон.</p> <p>4.1.3. Албан хаагчдын өдөр тутмын хамгаалах хэрэгсэл болох нэг удаагийн бээлий, амны хаалт зэргийг байгууллагын зүгээс ажилчдад тогтмол олгон ажиллаж байна.</p> <p>4.1.4. Ажилтан албан хаагчдын хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн хувцас солих, түр амрах, хооллох зориулалтаар хуучин оффис байсан 2 өрөөг тохижуулж ахуйн байртай болсон.</p> <p>4.1.5. Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх 21</p>			
--	--	--	--	--

		хоногийн сургалтад суусан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шалгалт өгч тэнцэн 20231452 дугаартай сертификат авсан.			
5	Байгууллагын хог хаягдлын байдал, ариун цэвэр, зохих хугацаанд ачуулсан байдал, тэмдэглэл хөтлөлт, баталгаажуулалт	5.1.Байгууллагын үйл ажиллагааны явцад үүсэн гарч байгаа хог хаягдлыг “Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний газар гурав” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулсны үндсэн дээр сар бүрд нэгээс хоёр удаагийн давтамжтайгаар ачуулж ажилласан байна.	Тийм	Байхгүй	Байгууллагын сахиул хог ачуулах дуудлага өгч, ачуулсны дараа бүртгэлийг хөтөлж, тэмдэглэл үйлдэн, түүнд эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан байнгын хяналтыг тавьж, баталгаажуулан ажилласан байна. МУ-ын “Хог хаягдлын тухай хууль”-ийн хэрэгжилт хангалттай байна.
6.	Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч болон бусад аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналт шалгалт	2023 онд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхээр шалгарсан 19 аж ахуйн нэгжүүд ямар нэгэн ноцтой зөрчил дутагдал гаргаагүй, гэрээний үүргийн хэрэгжилт сайн байна.	Тийм	Байхгүй	
7.	Харилцагч цэцэрлэг сургуулиудын хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, ариун цэвэр, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт.	Тайлант хугацаанд 1 дүгээр сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн 8 дугаар цэцэрлэгт, 2 дугаар сарын 15-ны өдөр 149, 289 дүгээр цэцэрлэгт тус тус менежер, 2 эрүүл ахуйчийн бүрэлдэхүүнтэйгээр очиж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Ноцтой зөрчил дутагдал илрээгүй. 2022-2023 хичээлийн жил дуусаж байгаатай холбогдуулан цэцэрлэгүүд хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлгүй байх шаардлагатай байдаг. Иймээс 05 дугаар сарын 22-ноос 31-ний хооронд менежер, эрүүл ахуйн 2 ажилтан, түгээлтийн нярвуудын хамтаар эрсдэлтэй гэж үзсэн 17 цэцэрлэгээр очиж хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг	Тийм	Байхгүй	



		<p>зохицуулах, үлдэгдэлгүй ажиллах, захиалгаа тохируулах зэргээр зөвлөн туслах үйлчилгээг өгч ажилласан.</p> <p>Мөн 10 дугаар сарын 25-ны өдөр “Харилцагч цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, хүнсний агуулахад зөвлөх үйлчилгээ”-ний ажлын удирдамжийг, ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамтаар байгууллагын захирал баталсан. Бүрэлдэхүүнд менежер Б.Зоригоо эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Г.Энхбуд, Б.Болортуяа, хүний нөөц, ХАБ хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж 8-р сар буюу хичээлийн шинэ жил эхэлснээс хойш үйл ажиллагаагаа эхлүүлсэн 7 цэцэрлэг дээр очиж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан байна.</p>			
8	<p>Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй биечлэн ажилладаг албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэг, шинжилгээнд журмын дагуу хамруулсан эсэхэд хийсэн хяналт шалгалт</p>	<p>8.1.Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвд байгууллагын нийт 28 ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан байна. Шинжилгээнд хамрагдсан бүх ажилтнууд эмчийн үзлэгээр тэнцсэн болно.</p>	Тийм	Байхгүй	<p>Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу хагас жил тутамд үзлэг шинжилгээнд хамрагдах талаар 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын Дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.2.12 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Ажилтнуудын шинжилгээний дүнгээр халдварт болон ажилд харшлах өвчин эмгэг илэрсэн ажилтан байхгүй байна.</p>

9.1	Өмч хөрөнгийн тооллогын байдал	9.1.1.Тооллогын комисс 2023 оны 6 дугаар сарын 29-30-ны хооронд эд хөрөнгийн тооллогыг хийж дуусгасан байна. Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэл хөтлөлт хэвийн байна.	Тийм	Зарим нэг эд хөрөнгийн коджилт дутуу, арилсан хууларсан байдалтай байна.	Ажил хэвийн явагдаж эхлэх үед буцаан хүлээлгэн өгөх
9.2	И-баримтын бүрдэл	9.2.1..Худалдан авсан болон худалдан борлуулсан бараа бүтээгдэхүүний үнийн дүн и-баримтаар баталгаажсан байх	Тийм		Тус байгууллагуудтай холбогдон шивүүлэх
9.3	Харилцагч байгууллагуудын авлага өглөгийн тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэхэд хяналт тавих	9.3.1.Улирал тутам харилцагч байгууллагуудтай өглөг авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар харилцан баталгаажуулсан байна.	Тийм	Түүвэрлэн үзсэн албан байгууллагуудтай тооцоо нийлж, тооцоо нийлсэн акт үйлдсэн байна.	
9.4	Няrvуудын ажил үүргийн дагуу хийгдэж байгаа анхан шатны баримт бичгүүдийн бүрдлийг хянах	9.4.1. Борлуулалтын няrvууд агуулахаас бараа хүлээн авсан болон цэцэрлэгүүдэд түгээсэн бараа материалын хөдөлгөөнтэй холбоотой бүхий л баримтуудыг бүрдүүлэн сар улирал бүрээр хянан үдэж хүлээлгэн өгсөн байх	Тийм	Няrvуудын орлого зарлагын баримтын бүрдэл сонгогдсон огноогоор бүрэн байна.	НББ-н тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчиж буй тул тухайн тайлант хугацаанд баримтын бүрдлийг зохих ёсоор ханган ажиллах,
9.5	Нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж тайлагнасан эсэхэд хяналт тавих	9.5.1. Сар бүрийн НД-н тайланг дараа сарын 5-ны дотор илгээн батлуулан ажиллаж байна.	Тийм	Байхгүй	Хуулийн хугацаанд тайланг илгээсэн байна.

9.6	Байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон бүх татварын тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж тайлагнасан эсэхэд хяналт тавих	9.6.1. ХХОАТ-ын болон ААНОАТ-ын тайланг улирал бүр хугацаанд нь гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн тайлагнасан байна.	Тийм	Байхгүй	Байхгүй
9.7	Байгууллагын жилийн санхүүгийн тайлан, зардлын шинжилгээ, зорилтот түвшний биелэлтийг хугацаанд нь гаргаж харьяалагдах дээд байгууллагад тушаасан байдалд хяналт тавих	9.7.1.Жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайлан урьдчилсан тайлан гарсан байна. Санхүүгийн тайлан иж бүрэн гарсны дараа тайлангийн мэдээлэлд үндэслэн зардлын шинжилгээ, зорилтот түвшний биелэлтийг хийж гүйцэтгэнэ.	Тийм	Байхгүй	Холбогдох тайлан мэдээллийг хугацаанд нь хүргүүлэх
9.8	Санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж, <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг зохих хугацаанд нь тогтмол байршуулж байгаа эсэх.	9.8.1. 2023 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансанд зохих мэдээллүүдийг хугацаанд нь байршуулсан байна.	Тийм	Байхгүй	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв оруулж хэвших

10.1	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт зохих дүрэм журмын дагуу явагдаж байгаа эсэх	2022 оны архивын баримтыг холбогдох хууль журмын дагуу Байнга хадгалах 22 баримт, 70 жил хадгалах 3 баримт, Түр хадгалах 95 баримт нийт 120 баримтыг 2023 оны 1-р улиралд багтаан бүрэн бүрдэлтэйгээр хүлээн авч бүртгэлжүүлэн ажилласан байна.			2022 оны архивын баримтуудыг хууль, журмын дагуу 2023 оны эхний улиралд багтаан ажилтнуудаас бүрдлийг хангуулан хүлээн авч "Байнга", "Түр", "70 жил", "Тусгай төрөл"-өөр ангилан данс бүртгэл үүсгэж, архивлан хадгалж зохих журмын дагуу ашигласан байна.
11	Байгууллагын ажилтан, албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил	<p>Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 2023 онд шинээр баталсантай холбогдуулан байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 3 гишүүнтэйгээр байгууллагын захирлын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулсан. Дээрх хуульд нийцүүлэн байгууллагын "Ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг 2023 оны 10 дугаар сард шинэчлэн боловсруулж батлуулсан.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон ёс зүйн шинэ дүрмийг танилцуулах зорилгоор байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан.</p> <p>2023 онд ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн, ажил тасалсан ёс зүйн зөрчил гаргасан жолооч Т.Гансүхэд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Сахилгын шийтгэл ногдуулах тухай" Б/07, ачигч Э.Намсрайд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Сахилгын шийтгэл ногдуулах тухай"</p>	Тийм	Байгууллага дээр ачигч, жолооч нар ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэх, хэрэглэсэн үедээ ажлын байранд ирэх, ажил таслах, бусдыг хэл амаар доромжлох, танхайрах зэрэг нийтлэг зөрчлүүд гарсан.	Шинээр ажилд орж байгаа ажилтанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон албан тушаал /ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж байгууллагын үйл ажиллагаанд хориглосон, хязгаарласан зүйл заалтыг тодорхой тайлбарлан таниулж байна. Ажилтан албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх, ёс зүйг сахих чиглэлээр байгууллагын хурал болон бусад үйл ажиллагааны үеэр байнга сануулж байна. Мөн ажилтан албан хаагчдын ажилдаа ирсэн явсан цагийг бүртгэж хэвшсэн байна.

		<p>Б/09, жолооч Д.Ганбаатарт мөн өдрийн сахилгын шийтгэл ногдуулах тухай Б/10, түгээлтийн нярав Б. Бат-Эрдэнэд 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/54 дугаар тушаалаар тус тус сануулах, үндсэн цалинг тодорхой хугацаагаар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан</p> <p>Ачигч С.Пүрэвдалай ажлын байраа орхиж явсан тул 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/11, ачигч Т.Цэрэндорж нэр бүхий ажилтнуудын биед халдаж эрүүл мэнд, гоо сайханд гэмтэл учруулсан тул 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Б/27, ачигч П.Шинэбаяр худал хэлж шалтгаангүйгээр дараалан 4 өдөр ажил тасалсан тул 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Б/28, ачигч Н.Ганхуяг, Г.Бямбадорж, Г.Чинзориг нар согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ 4-7 хоног дараалан ажил тасалсан тул 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/55, Б/56, Б/57 дугаар тушаалаар тус тус ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулсан.</p> <p>Сануулах болон үндсэн цалинг тодорхой хугацаагаар бууруулах сахилгын шийтгэл авсан 5 ажилтантай байгууллагын удирдлагууд нэгбүрчлэн ганцаарчилсан уулзалт хийж зөрчил гаргасан шалтгаан нөхцлийг судалж, дахин сахилгын зөрчил гаргахгүй байх талаар сануулсан. Мөн эдгээр ажилтанд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Ажилтан албан хаагчийн ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн гэрээг дахин танилцуулж</p>			
--	--	---	--	--	--

		байгууллагын үйл ажиллагаанд хориглосон, хязгаарласан зүйл заалтыг тодорхой тайлбарлан таниулснаар дээрх ажилчид гаргасан зөрчлөө ухамсарлаж, дахин сахилгын зөрчил гаргаагүй.			
--	--	--	--	--	--

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН:

КОМИССЫН АХЛАГЧ:

Б.ЗОРИГОО

ГИШҮҮД:

Ш.ОТГОНЖАРГАЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Ш.СЭРГЭЛЭН